

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/21

Арвайхээр сум

┌ Дархлаажуулалтын 10 хоногийг зохион
байгуулах тухай ┐

Эрүүл мэндийн сайдын “Дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай” 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн A/192 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Өнөөдрийн вакцин ирээдүйн хамгаалалт” уриан дор 2023 оны 05 дугаар сарын 28-ний өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолоос хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах ажлыг эрчимжүүлж, хамралтад тандалт, эргэмж судалгаа хийж, хариу арга хэмжээг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг нарийвчлан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН БҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБАЯР

622301063

My Doc.tushaal/EMG